



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2014 оны 01 сарын 15 өдөр

Дугаар 09

Улаанбаатар хот

┌ Даатгалын байгууллага болон даатгалын
мэргэжлийн оролцогчид аудит хийх эрх олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.2.3, 6.2.4, Даатгалын тухай хуулийн 33.2.2, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 20.2.2 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2010 оны 149 дүгээр тогтоолоор батлагдсан “Даатгалын байгууллагад аудит хийх үйл ажиллагааг зохицуулах журам”-ын 2.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Энэ тогтоолын хавсралтад дурдсан нэр бүхий 6 аудитын компанид даатгалын байгууллага болон даатгалын мэргэжлийн оролцогчид аудит хийх эрхийг 3 жилийн хугацаагаар олгосугай.
2. Компанийн өөрчлөлт, аудиторуудын шилжилт хөдөлгөөний талаар тухай бүр Хороонд мэдээлж байхыг эрх авсан аудитын компаниудын удирдлагад үүрэг болгосугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.


ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000897

Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 09 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт



Шинээр эрх авах аудитын компаниудын нэрс

№	Аудитын компаниудын нэрс	Регистрийн дугаар	Улсын бүртгэлийн дугаар	Тусгай зөвшөөрлийн дугаар
1	“Алтанжолоо-Аудит” ХХК	2113902	9018091008	010-1997
2	“Алаг уул финанс-Аудит” ХХК	5544173	9018001071	119-2013
3	“Гроутфинанс аудит” ХХК	5742293	9018001078	127-2013
4	“Юнистар-Аудит” ХХК	5258847	9018001025	071-2009
5	“Тэд-Аудит” ХХК	2097141	9018001007	007-1996
6	“Бодит бүртгэл Аудит” ХХК	5190363	9018001018	059-2008

-----oO-----